

## ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,  
2018 оны 10-р сарын 17-ны байдлаар


2018 оны 10-р сарын 17-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 1.2 хувиар буурч, өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.9 хувиар өссөн байна.

**Махны дундаж үнэ:** 2018 оны 10-р сарын 17-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 0.6, үхрийн цул махны үнэ 1.6 хувь, адууны ястай махны үнэ 3.8 хувиар буурч, үхрийн ястай махны үнэ 0.4 хувь, ямааны ястай махны үнэ 4.3 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 2.6 хувь, үхрийн ястай махны үнэ 1.6 хувь, адууны ястай махны үнэ 1.3 хувь, ямааны ястай махны үнэ 7.7 хувиар өссөн бол үхрийн цул махны үнэ өөрчлөлтгүй байна.

2018 оны 10-р сарын 17-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 6370 төгрөг, үхрийн /ястай/ мах 7810 төгрөг, үхрийн цул мах 9330 төгрөг, адууны /ястай/ мах 5850 төгрөг, ямааны /ястай/ мах 4900 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).


**Зураг 1.** Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ, төгрөг



**Гурилын үнэ:** 2018 оны 10-р сарын 17-ны гурилын үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

**Будаа, элсэн чихрийн дундаж үнэ:** 2018 оны 10-р сарын 17-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй харин элсэн чихрийн үнэ өмнөх сараас 2 хувиар өссөн бол өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна. (Зураг2).

**Зураг 2.** Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ, төгрөг



**Төмс, хүнсний ногооны дундаж үнэ:** 2018 оны 10-р сарын 17-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 12.9 хувь, луувангийн үнэ 21.2 хувь, байцааны үнэ 10.7 хувь, хүрэн манжингын үнэ 7.8 хувиар буурсан бол, сонгины үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногоос луувангийн үнэ 2.3 хувь, байцаа 3.0 хувиар буурсан бол төмс, хүрэн манжин болон сонгины дундаж үнэ өөрчлөлтгүй байна.

**Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ:** 2018 оны 10-р сарын 17-ны байдлаар савласан /1 литрийн/ сүүний үнэ өмнөх сараас 1.5 хувь өмнөх 7 хоногоос 1.9 үнэ хувиар өссөн бол бусад сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Ургамлын тосны үнэ болон цөцгийн тосны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

**ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газар  
2018 оны 10-р сарын 17**